




ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХӨА-2022/09/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: https://audit.mn/?page_id=579 Хөвсгөл аймаг Мөрөн сум 2022 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Л.Мандахнаран Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	8
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	11
3.5.3 Авлага.....	11
3.5.4 Урьдчилгаа.....	Error! Bookmark not defined.
3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	12
3.5.6 Бараа материал.....	12
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	12
3.5.8 Өр төлбөр.....	12
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	13
3.5.10 Орлогын данс.....	13
3.5.11 Зардлын данс.....	13
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	14
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	16
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	16
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчилтэй холбоотой асуудал	16
4.2 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал	Error! Bookmark not defined.
4.3 Аудитын зөвлөмж	Error! Bookmark not defined.
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	Error! Bookmark not defined.



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СХС	Сум хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.03.25 № 01/293
танай _____-ны № _____-т

РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.АМАРТҮВШИН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Төсвийн төвлөрүүлэн захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Рашаант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсөв, санхүүгийн хувьд Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх, үүрэг хэрэгжүүлэхээс гадна Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1 дэх зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.



Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	653,170.1	900,408.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	49,549.1	234,064.9
33	АВЛАГА	151,011.8	142,660.3
35	БАРАА МАТЕРИАЛ	452,609.3	523,683.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,974,226.2	8,309,437.6
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	78,000.0	58,514.2
37300	Урт хугацаат зээл	78,000.0	58,514.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,896,226.2	8,250,923.5
39200	Биет хөрөнгө	7,685,874.7	8,053,787.6
39300	Биет бус хөрөнгө	210,351.5	197,135.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,627,396.4	9,209,846.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	89,887.9	96,471.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	89,887.9	96,471.3
41300	Өглөг	89,887.9	96,471.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,537,508.4	9,113,375.0
51	Засгийн газрын хувь оролцоо	8,537,508.4	9,113,375.0
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,554,709.7	2,554,709.7
51200	Хуримтлагдсан үр дүн	4,134,545.9	4,710,773.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,848,252.8	1,847,892.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,627,396.4	9,209,846.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,887,768.4	4,407,688.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	143,379.6	205,924.3
110	Орлогын албан татвар	78,183.5	66,981.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	78,183.5	66,981.9
113	Хөрөнгийн албан татвар	2,766.0	55,144.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	62,430.1	83,798.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,758,095.9	1,089,750.2
120	Нийтлэг татварын бус орлого	2,758,095.9	1,055,664.1
122	Тусламжийн орлого	0.0	34,086.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,986,292.9	3,112,014.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,215,466.7	3,706,489.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,215,466.7	3,706,489.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,138,806.7	3,614,488.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,803,609.7	1,852,880.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,498.2	249,017.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	438,678.1	461,614.9
2104	Хангамж, бараа материалын зардал	104,226.4	127,245.5
2105	Нормативт зардал	119,992.8	407,049.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,977.6	36,929.9
2107	Томилолт, зочны зардал	3,346.2	2,288.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,337.8	46,612.4



2109	Бараа үйлчилгээний бусад зардал	387,139.9	430,849.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,076,660.0	92,001.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,672,301.7	701,198.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	99,692.8	125,332.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,572,608.8	575,866.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,964,899.6	0.0	5,964,899.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	21,556.9	0.0	21,556.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,986,456.5	0.0	5,986,456.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-21,556.9	0.0	-21,556.9
9	Тайлант үеийн үр дүн	2,572,608.8	0.0	2,572,608.8
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,537,508.4	0.0	8,537,508.4
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,537,508.4	0.0	8,537,508.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	360.8	0.0	360.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,537,869.2	0.0	8,537,869.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-360.8	0.0	-360.8
19	Тайлант үеийн үр дүн	575,866.5	0.0	575,866.5
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,113,375.0	0.0	9,113,375.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,216,519.7	3,378,968.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	143,379.6	205,924.3
110	Орлогын албан татвар	78,183.5	66,981.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	78,183.5	66,981.9
113	Хөрөнгийн албан татвар	2,766.0	77,809.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	62,430.1	61,133.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	16,103.3	-9,496.1
1181	Газрын төлбөр	12,158.0	4,751.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	34,168.8	65,877.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,473.0	118,473.8
120	Нийтлэг татварын бус орлого	84,473.0	118,473.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,988,667.2	3,054,570.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,971,379.6	3,063,549.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,971,379.6	3,063,549.9



210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,889,533.4	2,966,982.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,803,913.4	1,852,880.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,498.2	249,017.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	445,206.2	438,957.2
2104	Хангамж, бараа материалын зардал	117,903.3	97,621.5
2105	Нормативт зардал	124,968.0	184,140.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,465.9	51,761.9
2107	Томилолт, зочны зардал	3,872.2	2,288.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,494.3	52,900.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,212.0	37,415.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,081,846.2	96,567.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	245,140.1	315,418.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	139,598.7	130,902.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	139,598.7	130,902.6
2200	Дотоод эх үүсвэрээр	139,598.7	130,902.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-139,598.7	-130,902.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-78,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	78,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	27,541.4	184,515.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,007.6	49,549.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	49,549.1	234,064.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,096,559.10	2,967,728.94	128,830.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,894,637.50	2,862,298.67	32,338.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,853,102.10	2,820,763.27	32,338.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,820,255.70	1,810,403.19	9,852.51
210101	Үндсэн цалин	1,252,942.40	1,241,078.81	11,863.59
210102	Нэмэгдэл	456,236.70	458,668.58	(2,431.88)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,600.00	6,600.00	-
210104	Урамшуулал	100,921.60	100,500.80	420.80
210105	Гэрээт ажлын хөлс	3,555.00	3,555.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	245,734.30	243,738.80	1,995.50
210201	Тэтгэврийн даатгал	172,924.30	171,514.52	1,409.78
210202	Тэтгэмжийн даатгал	18,202.40	17,886.96	315.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,561.90	14,549.75	12.15
210204	Ажилгүйдлийн даатгал	3,640.50	3,620.75	19.75
210205	Эрүүл мэндийн даатгал	36,405.20	36,166.83	238.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	438,038.50	436,850.36	1,188.15
210301	Гэрэл, цахилгаан	18,760.40	16,579.29	2,181.11
210302	Түлш, халаалт	415,958.10	417,048.66	(1,090.56)
210303	Цэвэр, бохир ус	3,320.00	3,222.40	97.60



2104	Хангамж, бараа материалын зардал	75,111.90	73,668.95	1,442.95
210401	Бичиг хэрэг	6,517.40	6,517.40	-
210402	Тээвэр, шатахуун	39,382.00	37,939.05	1,442.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,627.70	9,881.80	(254.10)
210404	Ном, хэвлэл	982.20	982.20	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,569.00	9,314.90	254.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,033.60	9,033.60	-
2105	Нормативт зардал	110,965.40	97,273.22	13,692.18
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,456.60	28,387.94	1,068.66
210502	Хоол, хүнс	77,803.70	65,180.18	12,623.52
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,705.10	3,705.10	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	84,569.90	84,569.90	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,800.00	39,800.00	-
210602	Тавилга	6,000.00	6,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,082.00	1,082.00	-
210604	Урсгал засвар	37,687.90	37,687.90	-
2107	Томилолт, зочны зардал	2,170.60	2,000.70	169.90
210702	Дотоод албан томилолт	2,170.60	2,000.70	169.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,860.30	48,280.15	(419.85)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,005.60	43,940.45	(934.85)
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,463.00	1,948.00	515.00
210803	Даатгалын үйлчилгээ	245.40	245.40	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191.10	191.10	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102.60	102.60	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300.00	300.00	-
210807	Газрын төлбөр	461.40	461.40	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,091.20	1,091.20	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,395.50	23,978.00	4,417.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,649.00	4,231.50	4,417.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,746.50	19,746.50	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,535.40	41,535.40	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,535.40	41,535.40	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,285.40	36,285.40	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,250.00	5,250.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	124,383.30	79,085.76	45,297.54
223001	Бусад хөрөнгө	124,383.30	79,085.76	45,297.54
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	77,538.30	-	77,538.30
230001	Эргэж төлөгдөх зээл	77,538.30	-	77,538.30
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,096,559.10	3,068,969.59	27,589.51
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,013,988.40	1,991,203.59	22,784.81
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,913,148.80	1,890,363.99	22,784.81
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	100,839.60	100,839.60	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	934,444.30	940,624.36	(6,180.05)
320001	Орон нутгийн төсвөөс	934,444.30	940,624.36	(6,180.05)



33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,572.80	30,643.69	6,929.11
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	37,572.80	30,643.69	6,929.11
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	110,553.60	106,497.95	4,055.65
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	75,550.00	98,818.19	(23,268.19)
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,976.70	7,679.76	(3,703.06)
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	31,026.90	-	31,026.90
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,461.50	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	152,455.04	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6	-
610001	Төсвийн байгууллага	6	6	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	157	157	-
620001	Удирдах ажилтан	13	13	-
620002	Гүйцэтгэх ажилтан	96	96	-
620003	Үйлчлэх ажилтан	48	48	-
620004	Гэрээт ажилтан	-	-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	157	157	-
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	-
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	-	-	-
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	-	-	-
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	64	64	-
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	-	-	-
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4	4	-
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	-	-	-
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19	19	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	53	53	-
650010	Гэрээт ажилтан	-	-	-
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	216,222.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	212,242.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	179,995.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	42,477.60
210104	Урамшуулал	42,477.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,278.15
210201	Тэтгэврийн даатгал	3,620.55
210202	Тэтгэмжийн даатгал	130.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	414.50
210204	Ажилгүйдлийн даатгал	283.96



3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Амартүвшин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын тайланд үйлчлүүлэгчийн харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд гарсан алдаа, зөрчил, төсвийн төлөвлөлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 14-өөс 2021 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Л.Мандахнаран хариуцан гүйцэтгэж, ахлан аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хянаж, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар баталгаажуулж ажиллаа.

Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт Рашаант сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/101 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоот хяналт

Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Төсвийн ил тод байдлыг хангаж, төсвийг үр ашигтай зарцуулж, төсвийн хэтрэлтгүй ажиллах” гэсэн эрхэм зорилгоо дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу 2019 онд батлагдсан ба аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас нэгдсэн байдлаар боловсруулан мөрдүүлж байна. Тус бодлогын баримт бичигт тусгасан хууль, журам заавруудад өөрчлөлт орсон тул бодлогын баримт бичгийг шинэчлэх шаардлагатай байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүү тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Рашаант сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан нь харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 тоот тушаалын 2 дугаар хавсралтын дагуу нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл



баримтлалын дагуу мөр, мөрөөр нэгтгэж бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,706.5 сая төгрөгийн 1.5 хувь буюу 55.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 44.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг дахин тодорхойлох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 49.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 234.1 сая төгрөг болж 184.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.00	0.00	0.00
Банканд байгаа бэлэн мөнгө	49.6	234.1	184.5
Дүн	49.6	234.1	184.5
Үүнээс: байгууллагаар харуулбал			
Орон нутгийн ерөнхий орлого	45.1	81.6	36.5
Сум хөгжүүлэх сан	4.5	108.1	103.6
Орон нутгийн хөгжлийн сан	0.0	44.4	44.4
Нийт дүн	49.6	234.1	184.5

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 234.1 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд гүйлгээ байхгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 148.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 142.6 сая төгрөг болж 6.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт/+, -
Засаг даргын Тамгын газар	1.4	1.4	0.0
Сум хөгжүүлэх сан	147.2	60.2	-87.0
Эрүүл мэндийн төв	0.0	81.0	81.0
Нийт дүн	148.6	142.6	-6.0

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны журам өөрчлөгдөж шинээр зээл олгохгүй байгаа нь авлага буурахад гол нөлөөг үзүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:



Сумын ЗДТГ нь өмнөх оны санхүүгийн тайланын аудитаар өссөн 1.4 сая төгрөгийн авлагыг бараадуулах зөвлөмжийг биелүүлдэггүй тул албан шаардлага хүргүүлсэн байна. Эрүүл мэндийн төв нь цар тахлын үед үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний ЭМД-аас авах 81.0 сая төгрөгийн авлага үүссэн байна. Уг авлага 2022 оны 01 дүгээр сард төлөгдсөн байна.

3.5.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт
Тус дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 452.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 523.7 сая төгрөг болж, 71.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Засаг даргын Тамгын газар	73.8	97.5	23.7
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1.2	1.2	0.0
Соёлын төв	18.9	20.0	1.1
Ерөнхий боловсролын сургууль	218.0	223.9	5.9
Хүүхдийн цэцэрлэг	82.1	83.4	1.3
Эрүүл мэндийн төв	58.7	97.8	39.1
Нийт дүн	452.6	523.6	71.1

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

Бараа материалтай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,896.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,250.9 сая төгрөг болж 354.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт/+, бууралт/-
Засаг даргын Тамгын газар	774.5	900.6	126.1
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	151.2	148.7	-2.5
Соёлын төв	1.4	1.4	0.0
Ерөнхий боловсролын сургууль	4,431.5	4,369.1	62.4
Хүүхдийн цэцэрлэг	673.1	979.0	305.9
Эрүүл мэндийн төв	435.5	449.0	13.5
Нийт дүн	7,896.2	8,250.9	354.7

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 87.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 96.5 мянган төгрөг болж 9.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өссөн+ Буурсан -
Засаг даргын Тамгын газар	1.0	0.0	-1.0
Соёлын төв	76.5	96.5	20.0
Ерөнхий боловсролын сургууль	10.0	0.0	-10.0
Хүүхдийн цэцэрлэг	0.0	0.0	0.0
Нийт дүн	87.5	96.5	9.0



Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:
Сумын өсблын төв нь 2016 оноос хойш жил бүр нэмэгдэж байгаа халаалтын төлбөрийн 96.5 сая төгрөгийн өглөгтэй байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн түвшинд болон эрх бүхий дээд шатны төсөө захирагч нарч хандаж дээрх өглөгийг баривдуулах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 8,537.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9,113.4 сая төгрөг болж 575.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/-I, бууралт I-I
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,554.7	2,554.7	0.00
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	0.00	0.00
Хуримтлагдсан үр дүн	4,134.6	4,710.8	576.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,850.6	1,847.9	-0.3
Нийт дүн	8,537.5	9,113.4	575.9

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн болох 575.9 сая төгрөгөөр өсөж, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү болох 0.3 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт:
Тухайн данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

3.5.10 Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 4,407.7 сая төгрөгийг орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 2,480.1 сая төгрөг буюу 36.0 хувиар буурсан байна.

Хүснэгт №7 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	143.4	205.9	62.5	43.6
Татварын бус орлого	2,758.1	1,089.8	-1,668.3	-60.5
Тусламж санхүүжилтийн орлого	3,986.3	3,112.0	-874.3	-21.9
Нийт дүн	6,887.8	4,407.7	2,480.1	-36.0

Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Өмнөх онд сургуулийн шинэ барилга үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч нийт орлого өссөн байсан нь энэ онд нийт орлогын дүн буурахад гол нөлөө үзүүлсэн байна.

Тайланд онд харьяа төсвийн байгууллагуудад олгосон нийт 945.5 сая төгрөгийн санхүүжилт, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн 22.7 сая төгрөгийн хөрөнгийн орлого, нийт 968.2 сая төгрөгийн хоорондын тооцооны орлогын гүйлгээг устгах бичилт хийж тохируулсан байна.

3.5.11 Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд нийт 3,831.8 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Үүнд:

Хүснэгт №8: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	4,215.5	3,706.5	-509.0	-12.1



Үйл ажиллагааны бус зардал	99.7	125.3	25.6	25.7
Нийт дүн	4,315.2	3,831.8	483.3	-11.2

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Аудитын илрүүлэлт:

Сумын ЕБС 1.4 сая төгрөгийг, ЗДТГ 1.3 сая төгрөгийг тус тус тэмцэн, уралдаан зохион байгуулахад зарцуулсан, нийт төсвийн гүйцэтгэлээр хэмнэлттэй ажилласаар нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд орон нутгийн орлогыг 140.7 сая төгрөгөөр төлөвлөж, 217.9 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулсан ба 77.2 сая төгрөгөөр буюу 54.8 хувиар давуулан биелүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №9: Орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Татварын орлого	133.7	205.9	72.2
2	Татварын бус	7.0	12.0	5.0
3	Дүн	140.7	217.9	77.2

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан болон хөнгөвчлөх байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар орлоготой хөнгөвчлөх аргаар өөрчлөлт илрээгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 151.7 сая төгрөгөөр төлөвлөж 184.2 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 32.5 мянган төгрөг буюу 21.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №10: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	121.5	144.3	22,817.1
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар	7.0	7.7	712.3
3	Газрын төлбөр	4.2	7.7	3,535.1
4	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	16.5	18.7	2,232.4
5	Зам ашигласны төлбөр	2.5	5.8	3.3
6	Нийт дүн	151.7	184.2	32.5

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 21.1 сая төгрөгөөр төлөвлөж 107.1 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 86.0 сая төгрөг буюу 408.8 хувиар давуулан биелүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №11: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	8.5	30.7	22.2
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	11.6	74.2	62.6
3	Агаарын бохирдлын төлбөр	1.0	2.2	1.2
4	Нийт дүн	21.1	107.1	86.0

Эх сурвалж: Рашаант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга



Рашаант сумын төсвийн төслийг төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар орлогоотой холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар орлогоотой холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

Төсвийн төлөвлөлт

Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төслийг төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын хүрээнд боловсруулж, дээд шатны төсөв захирагч нарт нэгтгэж хүргүүлээгүй байна. Зөвхөн орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа байгууллагуудын төсвийг авч хүргүүлсэн ба боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд нь аймгийн Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалын 1 дүгээр хавсралттай нийцэхгүй бөгөөд төвлөрүүлэн захирагчийн төсвийн сахилга бат алдагдах, төсвийн жилийн дундуур төсөвт олон удаа тодотгол зохицуулалт хийх, үр ашиггүй зардал гарах, орлогыг үндэслэлтэй төлөвлөж чадахгүй байх гэх мэт сөрөг нөлөөллийг үзүүлж болзошгүй байна.

Төсвийн гүйцэтгэл

Рашаант сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 13 хөтөлбөрт зориулан 2,901.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,804.5 сая төгрөгийг урсгал зардалд, 96.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ. Нийт зардлын 1,872.3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 96.8 сая төгрөгийг ОНХНС-аас, 776.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 118.1 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 37.6 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн жилийн турш Иргэдийн төлөөлөгчдийн тогтоол, болон аймгийн Засаг даргын захирамжаар сумын нийт төсвийг 195.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 3,096.6 сая төгрөг болгож баталсан байна. Сумын төсөвт тодотгол хийсэн тогтоолд сумын төсвийн өөрчлөлт, санхүүжүүлэх эх үүсвэрийг ойлгомжтой тодорхой тусгаж өгөөгүй байна.

Аудитын илрүүлэлт: Сумын төсөвт баталгахдаа зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхой тусгаагүй, СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлого болох 74.0 сая төгрөгийг сумын нийт төсөвт оруулж төлөвлөж, батлуулаагүй байна. Дээрх зориулалд зөвлөмж хүргүүлээ.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 3,096.6 сая төгрөгөөр төлөвлөж, 3,054.6 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 98.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 79.5 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөж гүйцэтгэлээр 106.5 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна. СХС-ийн эргэн төлөлт өндөр гүйцэтгэлтэй байгаа нь тус сангийн зээлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн сантай холбож зээлжих зэрэглэлд хамааруулж эхэлсэнтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн тайланг нэгтгэн гаргах үүрэгтэй.

Тайланд онд Рашаант сумын ТТЗ-ийн харьяа байгууллагууд хандив тусламжаар 11.1 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 59.7 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 2.4 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 143.1 сая төгрөг, нийт 216.1 сая төгрөгийг орлогыг бүрдүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй



Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, 146 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмж биелэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан, 8 төсвийн гүйцэтгэлийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 85.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 4 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн байна.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сумын соёлын төв нь 2018 оноос хойш жил бүр нэмэгдэж байгаа халаалтын төлбөрийн 96.5 сая төгрөгийн өглөгтэй байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн түвшинд болон эрх бүхий дээд шатны төсөв захирагч нарт хандаж дээрх өглөгийг барагдуулах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна. Дээрх асуудлыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар орон нутгийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт, харьяа төсвийн байгууллагуудад илэрсэн зөрчилтэй холбоотой 3 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Залруулга

Рашаант сумын Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулга хийгээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Рашаант сумын Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Рашаант сумын Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

4.4 Зөвлөмж

4.4.1 Илрүүлэлт:

Сумын төсвийг батлахдаа зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхой тусгаагүй, СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлого болох 74.0 сая төгрөгийг сумын нийт төсөвт оруулж төлөвлөж, батлуулаагүй байна. Энэ нь “Төсвийн тухай хууль”-ийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь “төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн төслийг боловсруулахдаа санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхой ойлгомжтой харуулах, сумын төсвийг батлахдаа төсвийн захирагч бүрийг хамруулах

4.4.2 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 85.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн тул хэрэгжилтэд анхаарч ажиллан, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэн ирүүлэх

4.4.3 Илрүүлэлт:

Тайлант онд сумын ЕБС 1.4 сая төгрөгийг, ЗДТГ 1.3 сая төгрөгийг, ИТХ 0.3 сая төгрөгийг тус тус тэмцээн, уралдаан зохион байгуулахад зарцуулсан, сумын ИТХ нь төсөв батлах хуралдаан зохион байгуулахдаа 2.0 сая төгрөгөөр сумын иргэдийн төлөөлөгчид болон бусад оролцсон хүмүүсийг хоолонд оруулсан байна. Мөн сумын төсөвт байгууллагууд нийт төсвийн зарцуулалтаар хэмнэлт гаргаж ажиллаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1, 1.5, 1.6 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Засгийн газар болон бусад эрх бүрий байгууллагаас тухайн жилийн төсөвтэй холбоотой гаргасан тогтоол, тушаал шийдвэрийг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Рашаант сумын ЗДТГ	2	2.7					1	1.4	1	1.3
2	Рашаант сумын ЕБС	1	1.4							1	1.4
3	Рашаант сумын ЭМТ	1	81.0							1	81.0
4	Рашаант сумын ИТХ	1	2.3							1	2.3
	Дүн	5	87.4					1	1.4	4	86.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Рашаант сумын ЭМТ	1								1	
	Дүн	1								1	
	Нийт дүн	6	87.4					1	1.4	5	86.0

АУДИТЫГ ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

ХӨА-2022/09/НА-СТА-ТТЗ

А.ЭРДЭНЭБААТАР

 Б.ТЭГШДЭЛГЭР

 Г.ЭРДЭНЭЧИМЭГ

 Л.МАНДАХНАРАН III/23

 ТТЗ зорилго ЖЧ + 2.3 +